



ISSUE #15

9 December 2011

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Энэ долоо хоногт Бага сургуулийн сурагчид маань Алиса Гайхамшгийн Оронд жүжгийг амжилттай тоглож бидэнд сонирхуулаа. Тайз засал, сурагчдын өнгө алагласан тоглолтын хувцаснууд сүрлэг сайхан байлаа. Энэхүү жүжгийг найруулан сургуулийн тайзнаа тоглуулсан хөгжмийн багш Karen Bailey Summers, Сарантунгаа нарт болон жүжигт тоглосон бага сургуулийн нийт сурагчиддаа баярлалаа. Тоглолтын бэлтгэл ажил, тайз засал, зураг дизайн, хөгжим, гэрэлтүүлэг, техник дээр ажилласан бүх хүмүүст талархал илэрхийлье.

Жигнэмэгийн худалдаа зохион байгуулсан эцэг эхийн зөвлөлийхөнд баярлалаа. Хичээлийн жилийн эхний хагасыг амжилттай дуусгаж байгаа та бүхэндээ баярлалаа.

Хуанлийн хуудсаар бид бас нэг жилийг ардаа орхиж байна. Хуучин оноо үдэж шинэ оноо угтах энэ мөчид бид өнгөрсөн жилд хийсэн ажлаа эргэцүүлэн бодож шинэ онд хийх ажлаа төлөвлөдөг уламжлалтай.

Эргэцүүлэн бодох нь IV хөтөлбөрийн нэг чухал хэсэг байдаг. Бага, Дунд сургуулийн хөтөлбөр болон дипломын хөтөлбөрийн хүрээнд сурагчид өөрсдийн хичээл сурлагандаа үнэлэлт өгч цаашид хэрхэн сайжруулах талаараа эргэцүүлэн боддог. Заримдаа энэ нь сургалтын үйл явцын хамгийн хэцүү хэсэг байдаг ч энэ үйл явцыг хүмүүс алдаанаасаа суралцах хэмээн нэрлэдэг. Юу ч гэж нэрлэсэн эргэцүүлэн сайтар тунгаан бодох нь бүтээлчээр сурах үйл явцын нэг чухал хэсэг байдаг.

Хуучин оноо үдэж шинэ оныг угтах энэ мөчид хүүхдүүдтэйгээ цаг гаргаж өнгөрсөн онд хичээл сургууль нь ямар байсан талаар хамтдаа ярилцаарай гэж би та бүхэнд уриалж байна. Гол зүйлийг нь анхааран үзэж яагаад эдгээр зүйлс нь хүүхдийн чинь хувьд чухал эерэг зүйлс байгааг нь ярилцаарай.

Сайн хийж чадаагүй болон шаардлага хангаж чадаагүй зүйлс нь яагаад тийм болов гэдэг талаар бас ярилцаарай. Өнгөрсөн жилийн алдаа оноон дээрээ тулгуурлан ирэх жилийн зорилтуудаа тодорхойлоорой. Эдгээр зорилтуудаа биелүүлэхийн тулд юу хийх хэрэгтэй вэ? Эцэг эхчүүдийн хувьд та бүхэн эдгээр зорилтуудаа хэрэгжүүлэхэд нь тэдэнд яаж туслах вэ?

Хичээлийн жилийн сүүлийн хагаст ямар ч зорилго тавилаа гэсэн та бүхэн хүүхдийнхээ багш нартай нь ярилцаж тэдний зөвлөгөөг авч хамтран ажиллаарай.

Захирал, Robert Stearns

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

12 сарын 16

Сурагчдын хичээл өдөр 12:00 цагт тарна.

12 сарын 19-1 сарын 8

Сурагчдын өвлийн амралт

1 сарын 9

Өвлийн амралтын дуусч хичээл эхэлнэ.

FRONT PAGE— THE MEDEE IS AVAILABLE ONLINE EACH WEEK AT: WWW.ISUMONGOLIA.EDU.MN

THE MEDEE

The Weekly Newsletter of the International School of Ulaanbaatar

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Ахлах ангийн сурагчид энэ долоо хоногт шалгалт өгч, Америкын коллежоос зочин ирж оксидуудтай ярилцаж, охид хөвгүүдийн сагсны баг тэмцээн зохион байгуулж олон арга хэмжээ явагдаж завгүй өнгөрлөө. Сурагчдын өвлийн амралт удахгүй эхлэх гэж байна. Иймээс та бүхэн сурагчдыг сайн амрааж, зөв хооллож хичээл амралтаа зөв зохицуулж эрүүл байхад нь анхаарал тавьж бидэнд туслаарай. Эрүүл байхын тулд бид хичээл сургууль, ажил амралтаа зөв зохицуулах хэрэгтэй.

Хүүхдүүдээ хичээлд нь жолоочоор хүргүүлдэг эцэг эхчүүд та бүхэнд хүүхдээ өвлийн хүйтэнд дулаан хувцаслаж явуулж байхыг уриалж байна. Өглөөдөө болон өдрийн туршид их хүйтэн байгаа бөгөөд зарим сурагчид малгай, ороолт, бээлийгүй тэр ч бүү хэл гадуур хүрэмгүй хичээлдээ ирж байгаа нь намайг гайхшруулж байна. Та бүхэн ийм эрсдэлтэй алхам бүү хийгээрэй.

Бага сургуулийн сурагчдын Alice in Wonderland тоглолтын үеэр ундаа худалдсан сурагчдын зөвлөлийн гишүүддээ баярлалаа. Тэд сурагчдыг баярлуулаад зогсохгүй жилийн эцэст болдог үдэшлэгийн фондондоо мөнгө хуримтлуулдаг юм. Сайн ажилласан сурагчиддаа баярлалаа!

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Бага сургуулийн сурагчиддаа баяр хүргэе! *Alice in Wonderland* жүжгийг тэд маш амжилттай тоглож бидэнд сонирхууллаа. Бага сургуулийн сурагчдын дуулж жүжиглэх ур чадварыг баяжуулж тэдний тоглолтыг мэргэжлийн өндөр түвшинд найруулан удирдсан багш Ms. Karen Bailey-Summers and Ms. Сарантунгаа нарт онцгойлон баяр хүргэе! Бага сургуулийн тоглолтыг зохион байгуулсан комиссын гишүүд болон сайн дураараа тусалсан олон хүмүүст бас талархал дэвшүүлье. Тоглолтын өмнө худалдаа зохион байгуулсан эцэг эхийн зөвлөлийхөнд баярлалаа.

Хүйтний улиралд зохицуулан сурагчид дулаан хувцаслаж ирж байгааг хараад би баяртай байна. Богинохон хугацаанд ч гэсэн гадаа (-25-с доош градус) тоглох нь өдрийн турш хичээлдээ анхаарахад нь сурагчдад тустай байдаг юм.

Бага Сургуулийн Эрхлэгч Rick Elya

ХАЯЖ ГЭЭГДҮҮЛСЭН ЭД ЗҮЙЛС

Эцэг эхчүүд та бүхний анхааралд,

Сургуулийн ресепшин дээр сурагчдын хаяж гээгдүүлсэн маш олон хувцас олдоод байна. Та бүхэн сургууль дээр ирж хүүхдийн чинь хувцас байгаа эсэхийг шалгана уу. Бидэнд эдгээр хувцсыг хадгалах өрөө байдаггүй бөгөөд эзэн нь ирж аваагүй хувцаснуудыг өвлийн амралтын өмнө 12 сарын 16-нд Хөгжлийн Бэрхшээлтэй хүүхдүүдийн Солонго төвд хандивлах болно.

Та бүхэнд баярлалаа.

ОУДС

Бэлэг дурсгалын худалдаа

Францын Соёлын Төв 12 сарын 9-нд (14:00-20:00), 12 сарын 10-нд (10:00—20:00) гар урлал, бэлэг дурсгалын худалдаа зохион байгуулна. Та бүхнийг урьж байна. Францын Соёлын Төв Дашчойлин хийдийн хажууд гадаад оюутнуудын байранд байрладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг www.afm.mn хаяг-р орж авна уу. Утас: 11 351914

Marie Lefèvre

(+976) 9520-2065